

турш бүрэлдэж тогтсон нь үнэн боловч өнөөдөр түүнд шинэ агуулга оруулдаг шинэ нийгмийн үйл явцын хамт хөгжин баяжиж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ХКН-аас ТӨЗО-ы хувьд авч явуулж буй арга хэмжээ нь феодалын хамжлагат нийгмийн хоцрогдлыг арилган нийгэм-эдийн засгийн дэвшилтэд өөрчлөлт хийж, энэ орны ард түмнийг хоцрогдлоос нь бүрэн чөлөөлөх ажил хийгдэж байгааг Төвдийн өнөөгийн бодит байдал харуулж байна.

ТӨВДИЙН СҮМ ХИЙД

Л. Лхамдулам

Цастын орон Төвд. Энэ нэрийг сонсоход юуны түрүүн буддын шашны нөлөө гүн шингэсэн эртний орон, олон жилийн түүхт сүм хийдүүдийн шижиртэн гялалзах алтан ганжир нарны хурц гэрэлтэй хослон нүд гялбуулж, үнэн сүсэгт олон түмний хөл үл тасрах гудмуудад хааяагүй тааралдах лам хуврагууд нүднээ үзэгдэх шиг.

Европын нэрт жуулч-эрдэмтдийн бүтээлүүдэд Төвдийг «бурхан шашин шид тарнийн орон» хэмээн онцлон олонтаа тэмдэглэсэн байдаг нь энэхүү орны талаар мэдэхийг хүссэн хэн бүхний сониуч занг өөрийн эрхгүй хөндөх ажээ. Төвдийн нийслэл Лхасын нэрийн гарал үүслийн учрыг хөөвөл дэлхийн хамгийн өндөрлөгт орших энэхүү өвөрмөц орны талаар олонхи жуулч-эрдэмтдийн хийсэн дээрх дүгнэлтийг давхар нотолно.

Төвдөд буддын шашныг дэлгэрүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэсэн хүн бол VII зууны эхэнд Төвдийн олон бутархай овог аймгуудыг нэгтгэн Туфаны төр улсыг байгуулсан Соронзонгомбо хаан юм. Тэрээр төр барих хугацаандаа Балбын Амчобарман хаан, Хятадын Тайзун хаантай ургийн холбоо тогтоож, Чизун, Вэн Чэн нэртэй хоёр гүнжийг хатнаа болгосон ба тэд Төвдөд ирэхдээ Шигжамүни бурхны хөрөг авчирч анхны бурхан шүтээний зууг Лхаст бариулсан түүхтэй.

«Нарны хот» хэмээгддэг Лхасын төвд орших Их зуу сүмийг цагаан ямаагаар шороо зөөлгөн орчны намаг балчгийг арилган бариулсан тухай домог яриа өнөөг хүртэл төвд үндэстэн ард түмний дунд ам дамжин яригдсаар иржээ. Төвдөөр ямааг «ра», шороог «са» хэмээн дууддаг тул тэр газрыг эхний үед «раса» хэмээн нэрлэж байлаа. Хожмоо Төвдөд буддын шашин дэлгэрч, сүм хийд олноор баригдан Төвд

1. «Миньцзу туаньцзе» 1985. № 11
2. «Сизан байти вэньда» Бээжин, 1988.
3. «Байкэ няньцзянь», 1985.
4. «Ши жа» (сэтгүүл, Драмсала. 1986. №3
5. «Жэньминь жибао» 1989. III. 24
6. «Жэньминь жибао» 1987. XI. 4
7. «Гуанминь жибао» 1989. III. 30
8. «Правда» 1986. VIII. 19
9. «Миньцзу туаньцзе» 1988. № 6
10. «Чайна квартири» 1988, 9-р сарын дугаар
11. «Төвдүүд төвдийн тухай» 1988
12. Танган гэдэг нь төвдийн дүрслэх урлагийн нэг өвөрмөц төрөл бөгөөд МЭ VII зууны эхээр үүсэн хөгжжээ.

нь умардын буддизмын төв хэмээгдэж, сүсэгтэн олон мөргөлчдийн хөл үл тасрах нэгэн газар болсонтой уялдаж энэхүү газрыг бурхан шүтээн мөргөлийн газар хэмээх болж «раса» нэр «ласа» болон хувирчээ. «Ласа» Төвдөөр «ариун бурхны орон, мөргөлийн газар, тэнгэрийн ордон» гэсэн утгатай¹

Ийнхүү цагаан ямаагаар шороо зөөлгөснөөс үүдэн буй болсон Лхас хотын нэр түүхэн он цагийн хүрдийн эргэлтэд өөрийн утга агуулгаар баяжигдан өнөөг хүрсэн нь энэ буюу.

X зууны сүүл гэхэд Төвдөд шашны үйл ажиллагаа улам идэвхижсээр эртний Энэтхэгээс үүсэлтэй Шагжамүни шашин Төвдийн төрийн шашин болов. XIV зууны сүүлээр Амдогийн Зонхов гэгч (1357—1419) бурхан шашны асуудалд шинэчлэлт хийж ламын шашны эх үүсвэрийг тавьсан ажээ. Ламын шашин буюу гэлүгван урсгал XV зууны эхээс эхлэн хүчээ авч Төвдийн шашны үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэх болсон байна. Энэ урсгалд бүх лам хуврагуудын 60 гаруй хувь сахил хүртэж,² сүм хийдийн 90 гаруй хувь хамрагдаж³ байсан нь үүнийг гэрчилнэ. Шашин дэлгэрч нөлөө нь тэлэхийн хэрээр сүм, дуган, дацан олширч тэдгээрт суух лам хуврагуудын тоо ч өссөөр байв. Шарын шашныг дэлгэрүүлэгч Зонхов 1409 оны эхээр Лхасын Их зуу хийдэд том хэмжээний хурал хийсэн нь дараа дараагийн үед уламжлагдсаар ирсэн Ерөөлийн хурал* юм. Тэр жилдээ түүний санаачилгаар шарын шашны анхны хийд Ганданг (гандан-төвдөөр баяр баясгалан гэсэн утгатай) барих ажил эхэлжээ.⁴ Таван жилийн турш барьсан энэхүү эртний хийдийг шарын шашин үүсч мандсан газар гэж үздэг. Гандан хийдийг Лхасаас зүүн зүгт 20 мод газарт багахан уулан дээр барьсан нь гадаад хэлбэрээрээ Далай ламын ордон Будалинтай ойролцоо. Энэ хийдэд байнга 3-4 мянган лам, зарим цагт 5-6 мянган лам шавилан суудаг байжээ.⁵ Гандан хийд мэдлэгтэй лам хуврагууд олноор төрүүлдгээрээ бусад хийдүүдээс илүү нэрд гарсан.

Төвдөд шарын шашны алдартай 4 том хийд байдгийн нэг нь дээр өгүүлсэн Гандан хийд бөгөөд үлдсэн 3 хийдийн Брэвэн, Сэра нь мөн Лхасын ойролцоо харин Дашлхүмбэ хийд Шигазед байдаг ажээ.

Брэвэн хийдийг (брэвэн-төвдөөр овоолсон үр гэсэн утгатай) 1416 онд Зонховын шавь Жамъяндорж (1379—1449) Лхасаас баруунтай 6 мод газарт Гэмпэл гэдэг уулын хормойд бариулжээ. Брэвэн нь шарын шашны хамгийн том хийд төдийгүй эрх мэдлийн хувьд бусдаас давамгайлна. Жилд нэг удаа болдог шашны уламжлалт Ерөөлийн хурлын гэсгүг* дээрх хийдийн тэргүүн хамба л томилох эрхтэй. Брэвэн хийдэд суух лам хуврагуудын тоо ч бусад хийдүүдээс илүү. Зарим номд лам нарын тоо 10 мянгад хүрдэг⁶ байсан гэх боловч ер нь бол 7-8 мянган лам байнга суудаг байжээ. Брэвэн хийд түүх, соёлын асар их өвтэй. Уг хийдэд Далай лам Гэндэндүб, II Далай лам Содномжамц, IV Далай лам Юндэнжамц нарын шарил бий. Тэндхийн цогчин дуганд 38 орчим тохой өндөр Майдар бурхан хадгалагдан үлдсэн нь урлалын нэгэн гайхамшигт тооцогдож байна. Брэвэн нь мэргэн төлөгчдөөрөө ихэд нэртэй хийдийн нэг.

Сэра хийдийг (сэра-төвдөөр алтан уул гэсэн утгатай) Зонховын шавь Жанцанцорж Санжа-Иш (1354—1435) гэгч Лхасаас баруун хойш

*—Ерөөлийн хурал—Төвдөд жил бүрийн 3-р сарын 5-ны өдрөөс 10 хоног үргэлжилдэг шашны томоохон хурал, «Соёлын хувьсгалын» үеэр тасарч байгаад 20 жилийн дараа 1986 оноос дахин сэргээсэн. Гэвч 1987, 1988 онд Төвдийн Лхаст болсон эсэргүүцлийн үймээнээс болж Ерөөлийн хурлыг аль болох бага хүрээнд цөөн тооны том хийдэд ёсолж байх шийдвэр гаргажээ.

*-гэсгү—шашны хурлын үеэр дэглэм журам сахиулдаг маш эрх мэдэлтэй лам

4 мод хэрийн газар тал дээр бариулжээ. Сүмийн барилгад алт нэлээд орсныг Сэра гэсэн нэрээс нь гадарлаж болно. Хийд нь 3 том барилгаас бүрдэх бөгөөд доторхи ханыг нь битүү алтаар бүржээ. Сүмийн 3 дээвэр нь мөн алтадмал тул алсаас ч ялгаран харагдана. Сэра хийдэд уртаараа бараг 70 см нэг тал нь гурван ирмэгтэй илд мэт хурц, нөгөө нь хүний толгойн хирийн бөндгөр шийдэм байдгийг хийдийн лам хуврагууд, 1419 онд анх Сэра хийдийг бариулах үед тэнгэрийн баруун хаяанаас унаж ирсэн гэж ярьдаг⁷ бөгөөд түүнийгээ эрдэнэ мэт үзэж, ихэд сүжиглэдэг ажээ. Уг хийдэд гол төлөв 5500 лам суудаг байсан ба зарим цагт тэдгээрийн тоо 7 мянгад хүрдэг байв.⁸

Зонховыг таалал төгссөний дараа түүний хамгийн бага шавь I Далай лам Гэндэндүб Төвдийн хойд хэсэгт Дашлхүмбэ хийдийг 1447 оноос эхлэн 20 жилийн турш бариулсан гэлцдэг. Хожим нь Банчин богд өргөтгөн сэргээж өнөөгийн төрх байдлыг олсон байна.⁹ Дашлхүмбэ хийдэд V-X Банчинбогдын шарил бий. Түүнчлэн уг хийдэд соёлын үнэт зүйлс, судар ном ихээр хадгалагдан үлджээ. Дашлхүмбэ хийдийн барилгын зохион байгуулалт нь маш цэгцтэй, эргэн тойрон таван хаалга бүхий битүү хэрэм хашаагаар хүрээлэгдсэн байдаг нь бяцхан хот лугаа адил харагдана. Дашлхүмбэ хийдийн хурал хуралддаг 10-аад том багана бүхий танхим нь 2000 хүний багтаамжтай. Жил бүрийн зуны эхэн сард Дашлхүмбэ хийдэд бурхдын хөргийн үзмэр болдог ба энэ өдөр хийд нь гуч гаруй метр урт даавуун дээр маш нарийн ур чадвар гарган зурсан Майдар бурхны хөргөөс адис авах гэсэн сүсэгтэн олноос эхлээд энд тэндээс ирсэн олон мянган мөргөлчнөөр дүүрч хөл тавих зайгүй болдог байна.

Дээр өгүүлсэн 4 хийдээс гадна Төвдөд том жижиг хэдэн мянган хийд байв. Тэдгээрийн ихэнхийг ХҮII зууны сүүл ХҮIII зууны эхээр барьжээ. 1694 онд Төвдөд шашны төрөл бүрийн урсгалын 1807 сүм хийдэд 97538 лам сууж байсан бол 1737 он гэхэд Далай лам, Банчин богдын мэдлийн 3477 сүм хийдэд 316231 лам хувраг, суух болж 40 жилийн хугацаанд сүм хийдийн тоо 2 дахин лам нарын тоо 3 илүү дахин тус тус өсчээ.¹⁰ Зөвхөн дээрх тооноос тухайн үед шарын шашин Төвдөд хэр зэрэг нөлөөгөө тэлж, сүм хийд нийгмийн амьдралд хичнээн чухал үүрэг гүйцэтгэх болсныг харж болно. Төвдүүд зөвхөн мухар сүсэг бишрэлээсээ болоод төдийгүй сүм хийд тухайн нийгмийн соёлын гол цөм нь болж байсан болохоор үр хүүхдээсээ аль болох олныг сахил хүртсэн лам болгон хийдэд суулгахыг эрхэмлэдэг байв. Хэрвээ өрх айл 3 хүүтэй бол хоёр хүүгээ, 5 хүүтэй бол гурвыг нь, ганц хүүтэй байсан ч түүнийгээ мөн л лам болгох шиг ариун үйл байхгүй хэмээн үзэж байлаа. Тэр ч байтугай 3 үедээ нэг ч ламгүй айлыг хамгийн муугаар хэлдэг байсан байна.¹¹ Тиймээс ч төвдийн хүн амын талаас илүү, эрэгтэйчүүдийн бол дийлэнх нь сүм хийдэд сууж байжээ.

Төвдийн шашин гэлүгва, нима, сажа гэх зэрэг маш олон урсгалтай боловч сүм хийдийн зохион байгуулалт ерөнхийдөө ижил төстэй. Ямар ч сүм хийд тэргүүн хамбатай, түүний удирдлаган дор хурал номын ажил эрхэлдэг цорж, хурал удирддаг унзад, хурлын дэг журам сахиулагч гэсгү, хийдийн санхүү хариуцдаг жасын даамал байна. Сүм хийдийг дотор нь цогчин, дацан, хамцан, мицан, жаса гэж хуваан үзэж болно. Цогчин гэдэг нь шашны хурал байнга хурдаг газар. Хийдийн доторхи сүм дугануудыг нийтэд нь дацан гэж нэрлэнэ. Томоохон хийдэд хэд хэдэн дацан байж болох ба лам нарын тоо ихэвчлэн хэдэн мянгаар яригдана. Дацангийн харъяанд манайхны

аймаг* гэж нэрлэдэг хамцан орох ба түүнд 200—300 лам багтана. Хамцан нь дотроо 50—60 лам бүхий мицанд хуваагддаг ажээ. Хийдийн хамгийн бага газар нь жаса юм. Энд 3—4 эсвэл 7—8 лам тухайн хийдийн бурхан тахилын ажлыг байнга сууж хариуцна.¹²

Төвдүүд хүүхдээ бүр багаас нь ихэвчлэн 6—8 насанд нь хийдэд шавиар оруулдаг байв. Тэд сурсан номынхоо хэрээр зэрэг дэв ахидаг ажээ. Эхний хоёр жил банди нар төвд үсэг үзэн цогчин уншлагад оролцох ба түүний дараа гэвш болж 2 жилийн турш хангал* цээжилнэ. Энэ хоёр шатыг амжилттай давсан тохиолдолд цаашдаа «их таван ухаан», «бага таван ухаан»-д суралцах үүд хаалга нээгдэх ажээ. Шашны буюу «их таван ухаан»-д 1. дуулахуйн, 2. шалгахуйн 3. урлахуйн, 4. анагаах, 5. дотоод ухаан зэрэг багтана. Иргэний буюу «бага таван ухаан»-д 1. одон орон буюу зурхайн, 2. яруу найраг, 3. хөгжим, бүжиг, 4. найруулах, 5, ёгт нэрийн ухаан орно. Тэдгээрээс шалгахуйн ухаанд суралцаж түүнийгээ хамгаалсан хүнд «гавж» цол олгодог ба анагаах ухааных «маарамба», хэл шинжлэлийн ухааных «аграмба», одон орон судлалынх «дооромбо» цол тус тус хүртдэг ажээ. Лам хуврагуудын дотроос хамгийн эрх мэдэлтэй нь Далай лам, Банчин богд бөгөөд түүний дараа номын багш Гандантыва орно. Гандантыва ердийн лам нар дундаас мэдлэгээрээ шалгарч гарч ирсэн багш лам юм.

Сүм хийдийг тухайн үеийн хамгийн гарын дүйтэй уран хүмүүсээр бариулж дотор нь зөвхөн шашны төдийгүй түүх соёлын шилдэг бүтээлүүдийг хадгалсаар ирсэн бөгөөд нэг ёсондоо ард түмний үе үеийн урлалын гайхамшиг болж байсан гэхэд хилсдэхгүй билээ.

Төвдийн сүм хийдийн хувь заяа «соёлын хувьсгалын» 10 жилд тун хөөрхийлөлтэйгээр хэлмэгдсэн байна. 3000 гаруй сүм хийдээс Далай ламын ордон Будалинг оролцуулаад ердөө л арваадхан үлдсэн ажээ.¹³ Тэдгээрийн хамт төвд үндэстэн ард түмний хэдэн үеийн түүх, соёлын өв устаж үгүй болсон юм.

Хятадын засгийн газраас 1979 оноос эхлэн Төвдөд шашны талаар чөлөөтэй бодлого явуулах болж, «соёлын хувьсгалын» үед сүйдсэн сүм хийдийг сэргээн засварлах, шинээр барих ажлыг хийж эхэллээ. Улсаас өнгөрсөн хугацаанд 36 сая юаний хөрөнгө гарган олон зуун сүм хийдийг засварлаж, шинээр барилаа.¹⁴ Одоо Төвдийн өөртөө засах орны хэмжээнд 1142 сүм хийд, шашны зан үйл үйлдэх газар буй болжээ.¹⁵ Сүм хийдэд суух лам нарын тоо ч мэдэгдэм өсч байна. 1930 оны эхээр 1—2 мянгад хүрэхгүй байсан лам нар 20 мянга гаруй болтлоо нэмэгджээ.¹⁶

Хятадын засгийн газраас авч хэрэгжүүлж буй энэ бүх арга хэмжээ нь нэг талаар сүсэгтэн олны санаа сэтгэлд нийцүүлсэн уян хатан бодлого болж, нөгөө талаар тус орны өнөө явуулж байгаа «нээлтэй» бодлогын хүрээнд жуулчлалыг өргөжүүлж, валют олоход багагүй түлхэц үзүүлж байгаа билээ. Түүнээс гадна дээрх арга хэмжээг сүүлийн үед, шашныг олон түмний санаа сэтгэлийг хордуулагч, тархи толгойг мунхуурагч мэтээр зөвхөн нэг талаас нь үзэж, шашинтай холбоотой болгоныг буруутгаж, ард түмний гараар бүтсэн урлалын гайхамшигт бүтээлүүдийг хайр найргүй эвдэн сүйтгэж, үгүй хийж байсан түүхийн балагт үеэ эргэн харж, түүнийгээ засч залруулахыг мэрийсэн бага ч болтугай оролдлого мөн хэмээн үзэж болох байна.

* — аймаг-Урьд цагт манай Гандантэгчлэн хийдэд суухаар ирсэн лам нарыг 30 аймагт хуваадаг байв. Энд тэндээс ирсэн лам нарыг нутгаар нь ялгаж аймаг болгодог байжээ.
—хангал-10 догшин бурхдын байдлыг дүрслэн бичсэн судар

1. «Миньзу туанье» 1986, № 5, 46-р тал; 1987 № 2, 32-р тал.
2. Мөн сэтгүүл, 1984, № 2, 44-р тал
3. «Занш и луньвэнь сюань» (Төвдийн тухай өгүүллүүдийн түүвэр) Сючан хот. 1985, 105-р тал
4. «Занзу шияо Зунзяо зы» (Төвд үндэстний түүхийн товч Шашны тухай дэд дэвтэр) Чэнду, 1980, 101-р тал
5. «Занши луньвэнь сюань» Сючан, 1985., 441-р тал
6. Г.Ц, Цыбиков, Избранные труды, том 1. стр. 173
7. «Занши луньвэнь сюань» Сючан., 1985, 106-р тал
8. Мөн тэнд, 75-р тал
9. «Сизан байти Вэньда» (Төвдийн тухай 100 асуулт хариулт) Бээжин., 1988, 61-р тал.
«Занзу шияо» Чэнду 1980, 103-р тал
10. «Миньзу туанье» 1984, № 2, 45-р тал
11. Мөн сэтгүүл, 47-р тал; «Занши луньвэнь сюань», Сючан, 1985, 89-р тал
12. «Занши луньвэнь сюань» Сючан. 1985.. 107—108-р
13. «Азия и Африка сегодня» 1984, No 1, стр. 54
14. «Сизан байти Вэньда» Бээжин, 1988. 57-р тал
15. Мөн тэнд 56-р тал
16. Мөн тэнд 59-р тал. «Мондай то кэнкю» 1984 № 10, 49-р тал